

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1. Төслийн нэр	2
1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл	2
1.3. Төсөл хэрэгжих талбайн байршил	2
1.4. Төслийн хүчин чадал, ажиллах горим, ажиллах хүч	3
1.5. Үйлдвэрийн үйл ажиллагаа	3
1.6. Үйлдвэрийн бүтэц, барилга байгууламж	3
1.7. Үйлдвэрийн тоног төхөөрөмж	4
1.8. Үйлдвэрийн технологийн горим	5
1.9. Түүхий эд, ус хэрэглээ, химийн бодисын хэрэглээ	6
1.9.1. Түүхий эд	6
1.9.2. Химийн бодисын хэрэглээ	6
1.10. Төсөл хэрэгжих талбайн дэд бүтэц	7
БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	8
2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	8
2.1.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт ..	8
2.1.2. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	10
2.1.3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	12
2.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт	16
2.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	17
2.4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	17
2.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	25
2.6. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	33
2.7. 2023 онд хэрэгжүүлсэн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	35

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Арьс шир боловсруулах үйлдвэр” төсөл

1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: “Булигаар” ХК
 Улсын бүртгэлийн гэрчилгээ: 9010001072
 Регистрийн дугаар: 2039184
 Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо
 Утас: 11-342657, 9905-5936

1.3. Төсөл хэрэгжих талбайн байршил

Төслийн талбай нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 2-р хорооны нутаг дэвсгэрт 2 га газарт хэрэгжинэ.



Зураг 1. Төслийн талбай орчмын өнөөгийн байдал

Хүснэгт 1. Төслийн талбайн газарзүйн солбилцол

№	X	Y	Талбай, га
1	106°53'17.955"	47°53'34.443"	2
2	106°53'17.920"	47°53'34.654"	
3	106°53'17.374"	47°53'35.853"	
4	106°53'16.204"	47°53'37.801"	
5	106°53'17.435"	47°53'38.095"	
6	106°53'19.751"	47°53'38.017"	
7	106°53'19.872"	47°53'38.041"	
8	106°53'24.257"	47°53'37.857"	
9	106°53'24.211"	47°53'37.270"	
10	106°53'24.517"	47°53'37.259"	
11	106°53'24.496"	47°53'37.006"	
12	106°53'24.169"	47°53'37.018"	
13	106°53'24.045"	47°53'35.504"	
14	106°53'23.896"	47°53'35.510"	
15	106°53'23.819"	47°53'34.833"	
16	106°53'23.744"	47°53'33.981"	
17	106°53'23.720"	47°53'33.549"	
18	106°53'23.139"	47°53'33.563"	

19	106°53'23.120"	47°53'33.346"
20	106°53'20.849"	47°53'33.385"

1.4. Төслийн хүчин чадал, ажиллах горим, ажиллах хүч


“Булигаар” ХК нь жилд 250 хоног, 8 цагийн үргэлжлэлтэй 1 ээлжээр хоногт 800 ш, жилд дунджаар 200,000 ш хагас боловсруулалт хийсэн бод, арьс, шир, 1150 м² боловсруулалт хийсэн арьс шир боловсруулах хүчин чадалтай. Одоогийн байдлаар үйлдвэрийн хүчин чадлынхаа 50%-ийг ашигладаг. Тус үйлдвэр нь нийт 78 ажилтантай.

1. Химийн боловсруулах цех
 - Шохой
 - Идээлэг
2. Механик боловсруулах цех
3. Гүйцэтгэн боловсруулах цех

1.5. Үйлдвэрийн үйл ажиллагаа

Арьс шир боловсруулах үйлдвэрлэл нь нойтон болон хуурай боловсруулалтын 25 технологийн дамжлагатай. Боловсруулалтын нэг өдрийн оролт нь 1500-2000 үхрийн шир бөгөөд технологийн цикл нь зундаа 21 хоног, өвөлдөө 25 хоног байдаг. Үйлдвэр нь 78 ажилтантай. Төсөл хэрэгжүүлэгч нь бод, богийн арьсыг хагас болон гүйцэт боловсруулан вэт-блю, краст, булигаар, гялгар хорм, артай хар хром, гутлын дотор зэргийг үйлдвэрлэн дотоод болон гадаадын зах зээлд борлуулдаг бөгөөд үндсэн хэрэглэгчид нь Монгол Улсад гутлын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг “Футура фэйшн” ХХК, “Хос-Аз” ХХК байна.

“Мон-Ит Булигаар”ХК нь сүүлийн 8 жилийн туршид Куба улсад гутлын дээд биений хэсгийн арьсыг “Футура фэйшн” ХХК-иар дамжуулан экспортлож байна. Боловсруулсан гутлын арьсыг нийлүүлэхэд одоогийн байдлаар 10 гаруй жижиг дунд гутлын болон жижиг эдлэлийн үйлдвэрлэл, 40 гаруй өрхийн үйлдвэрлэгч, мөн хагас боловсруулсан вэт-блюг Итали, Солонгос улсад экспортлож байна.



Зураг 2. Химийн боловсруулах цехийн зохион байгуулалт

1.6. Үйлдвэрийн бүтэц, барилга байгууламж

“Булигаар” ХК нь бүтэц зохион байгуулалтын хувьд:

- Үйлдвэрлэл
- Санхүү маркетинг
- Захиргааны гэсэн 3 хэсгээс бүрддэг.



Зураг 3. Үйлдвэрийн барилгын зураг

Тус компанийн үндсэн барилга, байгууламж нь 1976 онд баригдсан бөгөөд технологийн тоног төхөөрөмж болон инженерийн шугам сүлжээний хувьд бүрэн шинэчлэгдсэн тул тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. 2020 оны зун үйлдвэрийн барилга байгууламжийн хувьд бүрэн засвар хийж шинэчилсэн байна.

1.7. Үйлдвэрийн тоног төхөөрөмж

Тус үйлдвэрийн нийт тоног төхөөрөмж нь 1998 онд суурилагдсан бөгөөд дараах тоног төхөөрөмжийг ашигладаг. Эдгээр үндсэн тоног төхөөрөмжүүдэд барабан 5 ш, машин 1 ш, халимлах машин 1 ш, хусах машин 1ш, шүрших машин 1ш, тэнийлгэж сунгах рам 1 ш зэрэг орно.

Хүснэгт 2. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Үйлдвэрлэгдсэн улс
1	Барабанууд	Итали
2	Будгийн ёмкость 450 л	Итали
3	Шахах машин GJ3A	Итали
4	Шахах машин 2700 мм	Хятад
5	Шахах машин	Итали
6	Хусах машин 2	Итали -1, Чех -1
7	Хусах машин – 1700 мм	Итали
8	Хусах машин	Чех
9	Хуваах машин -2010	Итали
10	Хуваах машин	Итали
11	Махлах машин /хонины/	Чех
12	Махлах машин /үхрийн/	Чех
13	Лабораторийн тоног төхөөрөмж	Итали
14	Индүү машин 2700 мм	Итали
15	Хувиарлах ёмкость 600 л	Итали
16	Зоргодос дамжуулах шугам	Итали
17	Гүүхэн кран	Чех
18	Ачааны лифт	Орос
19	Бохир агаар цэвэрлэх систем	Итали
20	Барабаны ус хэмжих шугам	Итали
21	Арьс хэмжих машин	Хятад
22	Арьс голоор зүсдэг машин	Итали
23	Аккумулятор цэнэглэгч	Итали

24	Агааржуулалтын систем	Итали
25	Чөлөөт хатаалга	Итали
26	Тэлдэг хатаалага	Итали
27	Тосолгооны машин	Итали
28	Тоос цуглуулагч систем	Итали
29	Зүлгэх машин	Итали
30	Өнгө зүлгэх машин	Итали
31	PALISSONE VERTICALE FICINI-EU Зөөлрүүлэх машин	Итали
32	Molisse	
33	Incoma вакум хатаалга	Чех
34	Fimet талхах барабан	Итали
35	Carlessi усалгааны машин	Итали
36	Электрон хэмжих машин	Итали
37	Шүрших машин	Итали
38	Хатаагч дамжуулагч	Итали
39	Гар шүрших	Итали
40	Өнгөлөгч машин	Итали
41	Mostardini ротар арлах машин	Итали
42	Mostardini арлах машин	Итали
43	Gemata машин суурь будгийн агрегат	Итали
44	Пүү – 15 кг	Итали
45	Пүү 2000 кг	Итали
46	Хими станц	Итали
47	Ус хувиарлах станц	Итали
48	Поо	Итали
49	Цахилгаан тэргэнцэр	Итали

1.8. Үйлдвэрийн технологийн горим

Тус үйлдвэр нь:

- Үйлдвэрлэл
- Санхүү маркетинг
- Захиргааны гэсэн 3 хэсгээс бүрддэг.

Химийн боловсруулах цех, тоног төхөөрөмжийн хүчин чадлаараа ажиллахад өдөрт:

- Үхэр – 800 ш
- Хонь – 200 ш арьсыг ветблю болгох
- Үхэр – 250 ш
- Хонь – 1000 ш ветблю арьсыг суурь будаг хийж бэлэн болгоно.

Химийн боловсруулах цехэд Африкийн хатуу улаан модыг тосонд чанаж хийсэн, 2 мм-ийн гуулин ялтасаар доторлосон идээлэх, зумлах, шохойдлого, будгийн зэрэг зориулалттай маш сайн чанарын 26 барабанаас гадна арьс шир махлах, хуваах, хусах, шахах, индүүдэх, хэмжих машинууд ажиллаж байна. Хатаах, гүйцэтгэх цех нь тус бүртээ өдөрт үхэр 300-350 ш, 1000-1200 ш бэлэн болгон гаргана.

Үйлдвэрийн технологийн горим нь химийн /нойтон/ боловсруулалтын хэсэг, гүйцэтгэн боловсруулах гэсэн үндсэн дамжлагаар явагдана. Үүнд:

1. Химийн боловсруулалт:
 - Түүхий эд дэвтээлтийн барабан
 - Намаз түрхэх талбай
 - 1-р шохойдолтын барабан
 - Махлах машин
 - Угаалгын барабан

- Идээлгийн барабан
 - Шахах машин
 - Хусах машин
 - Будгийн барабан
2. Гүйцээн боловсруулах:
- Вакум хатаах
 - Гинжин хатаалга
 - Услах машин
 - Сунгах машин
 - Тэнийлгэх машин
 - Өнгө засал
 - Арьсны талбайг хэмжих машин

“Мон-Ит булигаар” ХК-ийн Арьс шир боловсруулах үйлдвэр нь дараах технологийн дамжлагуудтай. Үүнд:

- Дэвтээлэг
- Махлах
- Шохойдлого
- Хуваах
- Панель
- Идээлэх
- Шахах/хусах
- Суурь будаг/тосолгоо
- Талхих

1.9. Түүхий эд, ус хэрэглээ, химийн бодисын хэрэглээ

1.9.1. Түүхий эд

Тус үйлдвэрийн үндсэн түүхий эд нь үхэр, сарлагийн шир ба хонины арьс юм. Одоогийн байдлаар үйлдвэрт түүхий эдийг 20 орчим бэлтгэн нийлүүлэгчээс байнга худалдан авч байна.

1.9.2. Химийн бодисын хэрэглээ

“Булигаар” ХК нь Арьс шир боловсруулах үйлдвэрийн технологийн үндсэн туслах материал нь шүлтийн ба хүчлийн уусмалууд бөгөөд дараах нэр төрлийн химийн бодис ашиглана. Эдгээр бодисуудын тодорхой хувийг худалдаалахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Үйлдвэрийн химийн бодисын хэрэглэдэг химийн бодисын нэр төрөл, хэмжээ

№	Химийн бодисын нэр	Олон улсын нэршил	Химийн томъёо	Cas number	Хэмжээ, тн
1	Норгогч	Wettin agent	-	-	19
2	Карбонат натри	Sodium carbonate	NaCO ₃	497-19-8	20,4
3	Дэвтээлгийн энзим	Soaking agent	-	-	25,5
4	Чанар хамгаалагч бактерицит	Bactericide	-	1313-82-2	5,8
5	Натрийн сульфид	Sodium sulphite	Na ₂ S	16721-80-5	67
6	Натрийн гидросульфид	Sodium hydrosulphide	NaHS	-	40,5
7	Шохойлогын туслах материал	Liming auxiliary	-	7783-20-2	47
8	Сульфат аммони	Ammonium sulphate	/NH ₄ /2SO ₄	-	32
9	Хлорт аммони	Ammonium chloride	NH ₄ Cl	-	32

10	Зөөлрүүлэгч фермент	Bating enzyme	-	-	12,5
11	Атираа тэнийлгэгч	Anti-Wrinkle agent	-	-	16
12	Шохой арилгалтын туслах	Deliming agent	-	-	28
13	Формат натри	Sodium formate	-	64-8-6	48
14	Шоргоолжний хүчил	Formic acid	HCOOH	7664-93-9	57,480
15	Хүхрийн хүчил	Sulphuric acid	H ₂ SO ₄	-	32,6
16	Органик хүчил	Organic acid	-	-	9
17	Цайруулагч	Sequestering agent	-	-	8
18	Тос авагч	Degreasing agent	-	10101-53-8	19,130
19	Тослогч материал	Fatiquor	Cr ₂ /SO ₄ / ₃ *H ₂ O	144-55-8	108,250
20	Суурьлаг өндөржүүлэгч	Basifying agent	NaHCO ₃	-	9,9
21	Хромын сульфат	Basic chrome sulphate	-	-	177
22	Бикарбонат натри	Sodium bicarbonate	-	12336-95-7/14808-60-7	31,8
23	Чанар хамгаалагч мөөгөнцөрийн эсрэг	Fungicide	-	497-19-8-108-95-2/68603-87-2	3,8
24	Саармагжуулагч	Neutralizing syntan	-	-	13,5
25	Хром синтан	Chrome syntan	-	-	21,0
26	Нэмэлт идээлэгч	Syntan, synthetic	-	-	138,5
27	Ургамлын болон синтетик идээ	Vegetable and synthetic tanning	-	-	83,5
28	Хөрсний будаг	Dyestuff	-	-	34
29	Пигмент будаг	Pigment	-	107-98-2/111-76/2160875-66-1	15,619
30	Хальс үүсгэгч	Binder	-	-	91,948
31	Усан суурьтай лак	Lacquer	-	-	18
32	Пенетратор	Pemetrator	-	-	6,425
33	Вакс, филлер	Wax, filler	-	-	6,425
34	Хөндлөн холбогч	Crosslinker	-	-	0,438
35	Барьц сайжруулагч	Feel modifier	-	-	1,460
36	Анилин будаг	Aniline dyestuff	-	-	7,810
37	Давс	Sodium chloride	NaCl	7647-14-5	500
38	РАМ	Poly Acryl Amide	(C ₃ H ₅ No) _n	9003-05-8	200
39	РАС	Poly Acryl Amide	Нийлмэл	-	200
40	Манганий сульфат	Manganese sulfate	MnSO ₄	10034-96-5	100
41	Төмрийн сульфат	Iron sulfate	FeSO ₄	15244-10-7	50
42	Филлер	Filler	Нийлмэл	-	6,5
43	Альдегид	Aldehyde	Нийлмэл	-	10

1.10. Төсөл хэрэгжих талбайн дэд бүтэц

Цахилгаан хангамж: Төвийн эрчим хүчний системд холбогдсон.

Зам харилцаа: Төслийн талбай нь хатуу хучилттай зам дагуу байрлаж байна.

Цэвэр усны хангамж: Төвийн цэвэр усны шугамтай холбогдсон. Цэвэр, бохир ус татан, зайлуулах гэрээтэй.

Харилцаа холбоо: Утсан холбоонд үүрэн телефон холбоог ашиглах боломжтой бөгөөд дотоод сүлжээний систем, барилгын автомат хяналтын систем, дохиолол хамгаалалтын систем байна.

Дулаан хангамж: Төвийн дулаан хангамжийн системд холбогдсон.

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

“Булигаар” ХК нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 2-р хорооны нутаг дэвсгэрт “Арьс шир боловсруулах үйлдвэр” төслийн үйл ажиллагааг явуулахдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах зорилгоор Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг хүлээнэ. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй “Булигаар” ХК-иас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах баримт бичиг юм.

Тус 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Монгол улсын Байгаль хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох журам дүрэм, “Булигаар” ХК-ийн “Арьс шир боловсруулах үйлдвэр” төслийн 2023 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан боловсруулсан болно.

БОХТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 11 сарын 01-ний дотор БОАЖЯ-нд ирүүлж, мөн Нийслэлийн байгаль орчны газраар хянуулж ажлын хэсгийн дүгнэлтийг гаргуулах, Хан-Уул дүүргийн 20-р хорооны иргэдэд танилцуулж, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах нь зүйтэй.

2.1.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	БОМТ-нд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн хугацаа, давтамж	Биелэлт
1	Агаарт ялгарах бохирдуулагч үнэрийг хүлцэх хэмжээнд байлгахын тулд агааржуулагчийн иж бүрэн системийн найдвартай ажиллагааг хангах, ажилчдыг шүүгч хошуувчаар хангах	2023.05 сар	Үйлдвэрийн агааржуулагчийн иж бүрэн системийн засвар үйлчилгээ, байнгын ажиллагааг хянаж, ажилчдыг шүүгч хошуувчаар хангадаг. Биелсэн (Зураг 4).
2	Үйлдвэрийн дотоод агаарын температур халуун хүйтний хэмжээг тогтмол хянах, задгай гал, галын эх үүсвэр, шатамхай материалуудыг үйлдвэрт хадгалахгүй байх, химийн хортой болон аюултай бодисыг зориулалтын агуулахад хадгалах.	Тогтмол	Химийн хортой болон аюултай бодисыг зориулалтын агуулахад хадгалдаг. Биелсэн (Зураг 5).
3	Үйлдвэрийн арьс шир боловсруулахад ашигладаг химийн бодисуудтай ажиллагсадад, тухайн бодистой харьцах хүмүүст амны хаалт, хошуувч, хамгаалалтын хувцас /бээлий, нүдний шил г.м/ хэрэглэж хэвшүүлэх аюулгүй ажиллагааны зөвлөмж тогтмол өгч байх	2023.05 сар	Үйлдвэрийн арьс шир боловсруулахад ашигладаг химийн бодисуудтай ажиллагсадад, тухайн бодистой харьцах хүмүүст амны хаалт, хошуувч, хамгаалалтын хувцас /бээлий, нүдний шил г.м/ хэрэглэж хэвшүүлэх аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг ажил эхлэхээс өмнө тогтмол өгч ажилладаг мөн ажиллах хугацаанд ХАБЭА-н ажилтан тогтмол хянаж ажилладаг.

			Биелсэн (Зураг 4,6).
4	Үйлдвэрийн нойтон, хуурай цехийн агааржуулалтын системийн ажиллагааг тогтмол хянах, байнгын ажиллагааг хангах, үйлдвэрийн ажлын байрны дотоод агаарт орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасны дагуу Мэргэжлийн байгууллагаар хяналт-шинжилгээ тогтмол хийлгэж, стандартын шаардлагыг хангаж ажиллах	Тогтмол	Үйлдвэрийн нойтон, хуурай цехийн агааржуулалтын системийн ажиллагааг тогтмол хяналт тавьж ажилладаг. Биелсэн.
5	Үйлдвэр болон химийн бодисын агуулахын ажиллагсад бодистой ажиллах болон асгарсан бодисыг саармагжуулах, хурааж авах зэрэг ажиллагааны явцад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлгүй ажиллах зэрэг тохиолдолд бодист түлэгдэх, бодисын уураар амьсгалах, хордох зэрэг эрдэл үүсч болзошгүй тул хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сайтар ханган ажиллах.	Тогтмол	Үйлдвэр болон химийн бодисын агуулахын ажиллагсад бодистой ажиллах болон асгарсан бодисыг саармагжуулах, хурааж авах зэрэг ажиллагааны явцад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлгүй ажиллах зэрэг тохиолдолд авах арга хэмжээний зааварчилгааг тогтмол өг ажилладаг . Үйлдвэр дээр ХАБЭА-н ажилтан ажилладаг. Биелсэн (Зураг 6).
6	Химийн хортой болон аюултай бодисын хадгалалтын болон хадгалах хугацааны горимыг нарийн чанд баримтлах, ялангуяа тодорхой хугацааны дараа уурших, задрах гэмт мэтээр бүтэц найрлага нь өөрчлөгддөг тогтвортой биш бодис болон савлагааны материал нь хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай химийн бодисыг агуулахад хадгалахад үйлдвэрлэгчээс зааж өгсөн хугацааг хянаж, хуучин бодисыг эхэлж ашиглах зарчмыг баримтлах	Тогтмол	Химийн хортой болон аюултай бодисын хадгалалтын болон хадгалах хугацааны горимыг нарийн чанд баримтлах, ялангуяа тодорхой хугацааны дараа уурших, задрах гэмт мэтээр бүтэц найрлага нь өөрчлөгддөг тогтвортой биш бодис болон савлагааны материал нь хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай химийн бодисыг агуулахад хадгалахад үйлдвэрлэгчээс зааж өгсөн хугацааг хянаж, хуучин бодисыг эхэлж ашиглах зарчмыг баримтлаж ажилладаг. Биелсэн (Зураг 5,6).
7	Химийн бодисыг шатах, гал авалцах эх үүсвэр болон хамт хадгалж болохгүй бодисуудыг тусад нь хадгалах	Тогтмол	Химийн бодисуудыг аюулын зэрэглэл, шинж чанараар тусад нь хадгалдаг. Биелсэн (Зураг 5).
8	Химийн бодисын агуулахын хадгалах нөхцөлийг стандартын шаардлагын түвшинд тохижуулах, хор аюулын лавлах мэдээлэлд тусгагдсан зааврын дагуу хадгалах, ялангуяа химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд тусгагдсаны дагуу хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх.	2023.06 сар	Химийн бодисуудыг аюулын зэрэглэл, шинж чанараар тусад нь хадгалдаг. Биелсэн (Зураг 5).
9	Химийн бодисын агуулахад байгалийн болон механик автомат агааржуулалтын системийг суурьлуулах	2023.06 сар	Химийн бодисын агуулах нь механик автомат агааржуулалтын системтэй. Биелсэн (Зураг 5).



Зураг 4. Үйлдвэрийн агааржуулалтын систем, ажилчдыг хошуувчаар хангасан байдал



Зураг 5. Химийн хортой болон аюултай бодисыг зориулалтын агуулах



Зураг 6. Химийн бодистой харьцдаг ажилчдад ХАБЭА-н ажилтан тогтмол хянаж ажилладаг. Үйлдвэр, агуулах дээр химийн бодистой харьцах зааварчилгааны самбар, анхан тусламжийн эмийн сан, химийн бодисын асугаралтын үед ашиглах багаж хэрэслүүдийг байрлуулсан байна.

2.1.2. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	БОМТ-нд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн хугацаа, давтамж	Биелэлт
1	Үйлдвэрийн хашаанд ашиглагдахгүй 500 м ² байгаа талбайд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан нөхөн сэргээх, ногоон байгууламж, мод бүхий зурвас, цэцгийн мандал, зүлэгжүүлэлтийг зөвлөмжийн дагуу гүйцэтгэх	2023.05 болон 09 сар	Үйлдвэрийн хашаанд ашиглагдахгүй сул чөлөөтэй талбайд мод гарьж зүлэгжүүлж орчны тохижилтыг хийсэн. Биелсэн (Зураг 7).
2	Химийн бодисын агуулахын барилга байгууламж нь шалыг химийн үйлчлэлд тэсвэртэй зузаан материалаар хийсэн боловч нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч байх.	Тогтмол	Химийн хортой болон аюултай бодисыг зориулалтын агуулахын шаланд хатуу хучилт хийсэн. Биелсэн (Зураг 8).
3	Тээвэрлэлт, хадгалалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулах, химийн бодисыг хөрсөнд алдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх	Тогтмол	Тээвэрлэлт, хадгалалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулах, химийн бодисыг хөрсөнд алдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг ав ажилладаг. Үйлдвэр дээр ХАБЭА-н ажилтан ажилладаг. Тогтмол хяналт тавьж, зааварчилгаа өгч ажилладаг. Биелсэн
4	Химийн бодисын агуулахын ажлын байр нь тухайн бодисын хор аюулын лавлах	2023.05 сар	Химийн бодисын агуулахын ажлын байр нь тухайн бодисын хор аюулын

<p>мэдээлэлд заасан шингээгч материалаар (зориулалтын шингээгч, хуурай элс, тогтворжуулагч, үртэс гэх мэт) хангагдсан байна. Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслээр хангагдсан байх.</p>		<p>лавлах мэдээлэлд заасан шингээгч материал, химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслээр тоноглогдсон. Биелсэн (Зураг 9).</p>
---	--	---



Зураг 7. Үйлдвэрийн хашаанд ашиглагдахгүй талбайд зүлэгжүүлж мод тарьсан байдал



Зураг 8. Химийн хортой болон аюултай бодисыг зориулалтын агуулахын шаланд хатуу хучилт хийсэн байдал



Зураг 9. Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслээр хангагдсан байдал

2.1.3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	БОМТ-нд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн хугацаа, давтамж	Биелэлт
1	Арьс ширний үйлдвэрээс гарах бохир усыг урьдчилан цэвэрлэх байгууламж /тунгаагуур, элс тос баригч, шүүр, трап/ суурилуулсан байх	Үйлдвэрүүдтэй хамт	Үйлдвэрээс гарах бохир усыг урьдчилан цэвэрлэх байгууламж /тунгаагуур, элс тос баригч, шүүр, механик сараалж/ суурилуулсан Биелсэн (Зураг 10).
2	Үйлдвэрээс гарах бохир ус нь MNS 6561:2015 стандартыг мөрдөн ажиллах	Тогтмол	Үйлдвэрээс гарах бохир усыг төвийн бохир ус татан зайлуулах системд нийлүүлэхээс өмнө урьдчилсан цэвэрлэгээг хийдэг бөгөөд үйлдвэрийн бохир усанд жилд 2 удаа шинжилгээ хийлгэж хяналт тавьж ажилладаг. Мөн үйлдвэрт ашиглаж байгаа химийн бодис нормыг барьж ажилладаг. Биелсэн (Зураг 11).
3	Үйлдвэрээс гарч бу бохир уснаас сар бүр дээж авч итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх, бохир усны найрлагат хяналт тавих, стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээг авч ажиллах	2023.05,09 сард	Үйлдвэрээс гарах бохир усыг төвийн бохир ус татан зайлуулах системд нийлүүлэхээс өмнө урьдчилсан цэвэрлэгээг хийдэг бөгөөд үйлдвэрийн бохир усанд жилд 2 удаа шинжилгээ хийлгэж хяналт тавьж ажилладаг. Мөн үйлдвэрт ашиглаж байгаа химийн бодис нормыг барьж ажилладаг. Биелсэн (Зураг 11).



Зураг 10. Үйлдвэрээс гарах бохир усыг урьдчилан цэвэрлэх байгууламж / механик сараалж/ суурилуулсан байдал

2019-04

2020-10

УС СУВГИЙН ҮДИРХЭХ ГАЗАР
УСНЫ ТӨВ ЛАБОРАТОРИ
 WATER SUPPLY & SEWERAGE AUTHORITY
 CENTRAL WATER LABORATORY

Улаанбаатар 13340, Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 6.Доржийн гудамж
 Утас: +976 70157034, www.cwsl.mn

СОРИЛТЫН ТАЙЛАН
 TEST REPORT

Сорилтын тайлангийн дугаар /Report No. 231128
 Хүсэтгэгчдийн нэр /Client Мөн ИТ Бүлэгээр ХК
 Сорьц авсан хүний нэр, албан тушаал /Sampled by Тэнгэрбаяр, сорьц авач
 Холбоо барих мэдээлэл /Contact information Сонголт 09728828
 Дэд лабораторийн нэр /Sub laboratory name Хөвч

Өрөнхий шаардлага /General requirements	MNS ISO 9001:2015	Сорьц авсан өгнөө /Sampled date	2023/05/18
Сорьцны тодорхойлолт /Sample description	Аюулгүй татуурын сүтэжээг нөхдүүлэх хамдал үс industrial effluent to main sewerage system	Хүлээн авсан өгнөө /Received date	2023/05/18
Сорьц авсан аргачлал /Sampling method	MNS ISO 5667-5:2001	Шинжилсэн өгнөө /Analysed date	2023/05/18-2023/05/20

Дэд	Сорьцны код /Sample ID	Сорьц авсан газар /Sample location/source	Сорьц авсан цаг /Sample point	Хэмжээ /Sample quantity
1	6230754	ХУБ, Арьс шир боловсруулах үйлдвэр	тэргэртэй	0.5л

Дэд	Шинжилгээний аргачлал /Analytical method	Шинжилсэн үзүүлэлт /Parameters	Хэмжих нэгж /Unit	ЗДА /PC	6230754
Химийн шинжилгээний үр дүн /Chemical results					
1	MNS ISO 10523:2001	Усны орчны pH / pH value		6.9	9
2	MNS ISO 11923:2001	Үлбүүр бодас / Suspended solids	mg/L	400	170.3
3	MNS ISO 9080:2001	Химийн хэрэгцээт нүүцэт өрөгч / Chemical oxygen demand /COD-Cr	mg/L	800	1680
4	MNS 5597:2006	Сүльфид / Sulfide	mg/L	5	23.8
5	CS 11-3037:2008	Нийт хром / Total chromium	mg/L	1	0

End of Report

Харгалсан /Verified by

Цэцэг-Аюулын Болориа
Хөвч /chemical manager
Chemical quality manager

Байгаль /Approved by

Улаанбаатар 13340, Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 6.Доржийн гудамж
Утас: +976 70157034, www.cwsl.mn

Сорилтын тайланг бэлтгэжээний өдөр үүс, тасалгүй байх үүрэгтэй. This report should be issued without signature of the person and stamp.
 Сорилтын тайланг өгөгдөлийг хуульчлах буюу мөрдөхийг зөвшөөрнө. The test report should be issued if altered or tampered except in full.
 Хувийн дүрэм /Printed date: 2021/05/31

2023.05 сар

Зураг 11. Үйлдвэрийн бохир усны шинжилгээний бичиг

2.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

№	БОМТ-нд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн хугацаа, давтамж	Биелэлт
1	Үйлдвэрийн хашаанд жилд 500 м ² талбайд ногоон байгууламж, мод бүхий зурвас, цэцгийн мандал, зүлэгжүүлэлт хийх	2023.05 болон 10-р сард	Үйлдвэрийн хашаанд сул чөлөөтэй талбайд ногоон байгууламж, зүлэгжүүлэлтийг ажл хийсэн. Биелсэн (Зураг 12).
2	Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад хувь нэмэр оруулах зорилгоор 300м ² талбайд 1000 ш хайлаас мод суулгах төлөвлөсөн.	2023.05 болон 10-р сард	2019.5 сард 10 ш хайлаас модыг үйлдвэрийн орчимд тарьж амилттай ургуулсан. 2023 онд энэхүү ажлыг хэрэгжүүлээгүй бөгөөд 2024.5 болон 10 сард нэмэж тарихаар төлөвлөсөн. (Зураг 13).



Зураг 12. Үйлдвэрийн хашаанд ашиглагдахгүй талбайд зүлэгжүүлж мод тарьсан байдал



Зураг 13. Үйлдвэрийн талбайд хайлаас тарьсан байдал

2.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Тус төслийн талбай орчимд одоогийн байдлаар түүх, соёлын дурсгал, археологи, палеонтологийн олдвор илрээгүй байна. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сумын засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай.


2.4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	БОМТ-нд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн хугацаа, давтамж	Биелэлт
1	Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн аюул, осол гарахаас байнга урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, агуулахын бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих.	Тогтмол	Химийн хортой болон аюултай бодисыг зориулалтын агуулахад хадгалдаг. Биелсэн (Зураг 14,15).
2	Химийн бодисын агуулахад ажиллаж буй мэргэжилтэн нь хор аюулын лавлах мэдээлэлд заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллахаас гадна химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх, асгарч алдагдсан тохиолдолд түүнийг саармагжуулах арга хэмжээг авах чадварыг эзэмшсэн байх. /сургалт орох/	2023.10 сард	2023.10 сард химийн бодистой харьцдаг ажилчдын дунд “Химийн материал болон түүний асгаралтын үед авах арга хэмжээ, хамгаалах хэрэгслүүд” сэдэвт сургалтыг явуулсан. Сургалтад хамрагдсан ажилчдын 90% нь үнэлгээгээр асуулгад бүрэн хариулсан 100 оноо, 10% нь 75 оноо авсан байна. Тиймээс тус сургалтыг хүлээсэн үр дүндээ хүрсэн гэж дүгнэв. Биелсэн (Зураг 16).
3	Аюулгүй ажиллагааны зааварчилгааг өөрийн байгууллагын даргаар батлуулан ажлын байр болон агуулахад химийн бодистой харьцаж ажилладаг ажилтан өдөр тутмын ажиллагаанд ашиглаж байх боломжтой харагдахуйц газарт байрлуулах бөгөөд аюулгүй ажиллагааны зааварчилгаанд химийн бодисын хор аюул, үүсэж болох эрсдэл / хүний эрүүл мэнд, байгаль орчим/, химийн бодистой харьцах, хадгалах зааварчилгаа, асгарч алдагдсан болон галын аюулын үед авах арга хэмжээ, анхны тусламж, хувийн хамгаалах хэрэгсэл, хэрэглэх заавар, хаягдлыг устгах зааварчилгааг зэргийг багтаасан байна.	2023.05 сар	Химийн бодисын агуулах, үйлдвэр дээр “Химийн бодисын хор, аюулын лавлах мэдээлэл”, “Эрсдлийн үнэлгээ”, “Аюулын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөө”, “Химийн бодистой харьцах зааварчилгаа”, “Компанийн химийн бодисын менежментийн бодлого”, “ХАБЭА мэдээллийн самбар”, “Галын аюулаас урьдчилан сэргийлэх” “Анхны тусламжийн хээг” зэрэг баримт бичиг, зааварчилгааны самбар зэргийг ажилчдын нүдэнд ил харагдах газар байрлуулав. Биелсэн (Зураг 18-22).
4	Ажлын байран доторх бага хэмжээтэй химийн бодис хадгалах зөөврийн агуулахыг шат, аврах гарц, хонгилын эргэлтийн өнцөг, давчуу хонгил гэх мэт хүмүүсийн хөдөлгөөнд саад учруулах эрсдэлтэй газар болон албан тасалгаа, амрах өрөө, цайны газар, биеийн тамирын өрөө, эмнэлэгийн тусламжийн өрөөний ойр байрлуулах, орон сууц, худалдаа үйлчилгээний газрын болон албан байгууллагын байшингийн зоорийн давхарт хадгалахгүй байх.	Тогтмол	Химийн хортой болон аюултай бодисыг зориулалтын агуулахад хадгалдаг. Биелсэн (Зураг 14,15).
5	Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх хадгалахтай холбоотой үйл ажиллагааг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбайд явуулахаас гадна болзошгүй аюул, осол гарсан үед хүний эрүүл мэнд, эд хөрөнгө,	2023.05 сар	Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсээр үйлдвэрийн “Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө” боловсруулж батлуулсан. Биелсэн (Зураг 24).

	байгаль орчинд үүсэх хохирлыг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний дарааллыг тогтоосон “Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө” боловсруулж, тухайн орон нутгийн Онцгой байдлын газраар батлуулсан хэрэгжүүлэх.		
6	Химийн бодистой харьцаж ажилладаг ажиллагсдыг үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг хянах, эрсдэл үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах мэдлэг, дадлыг эзэмшүүлэх сургалтад заавал хамруулсан байх.	2023.10 сар	2023.10 сард химийн бодистой харьцаж ажилчдын дунд “Химийн материал болон түүний асгаралтын үед авах арга хэмжээ, хамгаалах хэрэгслүүд” сэдэвт сургалтыг явуулсан. Биелсэн (Зураг 16).
7	Химийн бодисын агуулахын болзошгүй аюул, ослын үед ашиглах, хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу бүрэн ажиллагаатай гал унтраах багаж, хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмал, химийн бодис асгарч алдагдсан үед ашиглах багаж, хэрэгсэл, шингээгч материал, хувийн хамгаалах хэрэгсэл (арьс, нүд, амьсгал хамгаалах), амьсгал хамгаалах баг, шаардлагатай тохиолдолд нүд угаах болон ослын шүршүүр зэргийг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ажиллах дадлыг эзэмшүүлэх.	Тогтмол	Химийн бодисын агуулахын болзошгүй аюул, ослын үед ашиглах, хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу бүрэн ажиллагаатай гал унтраах багаж, хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмал, химийн бодис асгарч алдагдсан үед ашиглах багаж, хэрэгсэл, шингээгч материал, хувийн хамгаалах хэрэгсэл (арьс, нүд, амьсгал хамгаалах), амьсгал хамгаалах баг, шаардлагатай тохиолдолд нүд угаах болон ослын шүршүүр зэргийг ажлын байранд байршуулав. Мөн ажилчдын дунд “Химийн материал болон түүний асгаралтын үед авах арга хэмжээ, хамгаалах хэрэгслүүд” сэдэвт сургалтыг явуулсан. Биелсэн (Зураг 23).
8	Химийн бодисын агуулахад утаа мэдрэгч, галын дохиоллын систем, даралт мэдрэгч болон тэсрэлт үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хий зайлуулагч автомат төхөөрөмж суурилуулах.	-	Химийн бодисын агуулахад утаа мэдрэгч, галын дохиоллын систем, даралт мэдрэгч болон тэсрэлт үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хий зайлуулагч автомат төхөөрөмж суурилуулах ажлыг 2024 оны БОМТ-нд тусгаж, 2024 оны 3 сард хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.




Зураг 14. Химийн хортой болон аюултай бодисыг зориулалтын агуулахад хадгаж байна.



Зураг 15. Химийн бодисын агуулахад мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн хийсэн дүгнэлт





Зураг 18. Үйлдвэрд ашиглагдаж буй химийн бодисуудын хор аюулын лавлах мэдээлэл, эрсдлийн үнэлгээг үйлдвэр болон химийн бодисын агуулахад байршуулав.




Зураг 19. Химийн бодистой харьцдаг ажилчдад ХАБЭА-н ажилтан тогтмол хянаж ажилладаг. Үйлдвэр, агуулах дээр химийн бодистой харьцах зааварчилгааны самбар, анхан тусламжийн эмийн сан, химийн бодисын асгаралтын үед ашиглах багаж хэрэслүүдийг байрлуулсан байна.



Зураг 20. Галын аюулаас урьдчилан сэргийлэх, анхан тусламжийн зөвлөмж, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг зөв ашиглах зөвлөмжийн самбарыг ажилчдад ил харагдах газар байрлуулав.




Зураг 21. Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр тоноглов.



Зураг 22. Химийн бодис хадгалалт, химийн бодистой харьцах бүхий зааварчилгаа, анхааруулах самбарыг үйлдвэрийн болон химийн бодисын агуулахын ханан дээр байрлуулав.



Зураг 23. Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслээр хангагдсан байдал



Зураг 24. Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсээр үйлдвэрийн “Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө” боловсруулж батлуулав.

2.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	БОМТ-нд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн хугацаа, давтамж	Биелэлт
1	Үйлдвэрийн хатуу хог хаягдал	Үйлдвэрийн хог хаягдал болон лагийн тунгаагуураас гарах хатуу хог хаягдлуудыг тогтмол хугацаанд тогтсон цэгт зайлуулж байх, ахуйн хог хаягдалтай нийлүүлэхгүй байх, хог хаягдлын цэгийн битүүмжлэлийг сайтар хянах	Тогтмол	<p>Үйлдвэр дээр ахуйн болон үйлдвэрийн технологийн хог хаягдал, химийн бодисын сав баглаа боодлыг тус тусад нь түр хадгалж “Ахуйн болон аюултай хог хаягдлын гэрээ”-г холбогдох байгууллагуудтай байгуулж гэрээний дагуу зөвшөөрөлтэй хог цэг болон аюултай хог хаягдал устгадаг компани руу зайлуулж байна.</p> <p>Хог хаягдлын цэгийн битүүмжлэлийг тогтмол хянадаг. Биелсэн (Зураг 25,26).</p>
2		Үйлдвэрийн хатуу хог хаягдлын цэгийг тусгайлан хөрсний бохирдол үүсэхгүй нөхцөлтэйгээр засах, тохижуулах, хөрсөнд ил задгай хатуу хог хаягдал хадгалахгүй байх, хатуу хог хаягдлын цэгийг хатуу хучилттай болгон тохижуулах засах	Тогтмол	<p>Үйлдвэр дээр үүсэж буй ахуйн болон технологийн, аюултай шинжтэй хог хаягдлыг тус тусад нь түр хуримтлуулдаг. Эдгээр хог хаягдлыг хөрсний бохирдол үүсэхгүйгээр хатуу хучилт хийсэн талбайд байршуулав. Биелсэн (Зураг 27).</p>

ХОГ ХАЯГДАЛ ХАЯХ ГЭРЭЭ

2023 оны 10 дугаар сарын 18

№ 2023/49

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас "Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ /цаашид "А" гэх/ түүнийг төлөөлж газрын дарга Б.Мөнхцэцэг, нөгөө талаас "Булигаар" ХК РД.2039184 /цаашид "Б" гэх/ түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Батчулуун Анхболд /хамтад нь "талууд" гэх/ нар Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 109-р тогтоол, Хот тохижилтын газрын 2016 оны дүрэм, 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 32/03 дугаар тогтоолоор батлагдсан Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам зэргийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Үндсэн нөхцөл

1.1 Б тал нь Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо, Арьс ширний үйлдвэрийн хашаа Булигаар ХК-ийн өөрийн байрнаас үүсэх хог хаягдлыг **42-01 УАА,98-01 УБГ** улсын дугаар бүхий автомашинаар тээвэрлэн, Хан-Уул дүүргийн Биокомбинат дахь төвлөрсөн хогийн цэгд хаях хог хаягдалыг А талын пүүнд хэмжилт хийж, баримт үйлдсэнд үндэслэн ажлын хөлсийг Б тал нь гэрээнд заасан хугацаанд нь төлөх санхүүгийн харилцааг зохицуулна.

Хоёр. Төлбөр, тооцоо хийх журам

- 1.1 Нэг тонн хог хаягдалын үнэлгээ: **4350 /дөрвөн мянга гурван зуун таавь/** төгрөг байна. НӨАТ шингэсэн үнэ болно.
- 2.2 Зориулалтын цэгт хог хаягдал хаях үеийн нийт тонн, хэмжээний төлбөрийг сар бүрийн 30-ны өдрөөр тооцоо нийлж, А талын **Хаан банкны 5064975024** тоот дансанд нэхэмжлэхийн дагуу шилжүүлнэ.
- 2.3 "Хог хаягдлын тухай" хууль, бусад эрх зүйн актын өөрчлөлт, зах зээлийн үнийн өөрчлөлтөөс хамаарч А талын үнэ тарифт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

Гурав. Гэрээний үйлчлэх хугацаа

- 3.1 Гэрээний үйлчлэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоов.
- 3.2 Гэрээ үйлчилж эхлэх хугацаа: 2023 оны 10 дүгээр сарын 18-ны өдөр байна.
- 3.3 Гэрээний дуусах хугацаа: 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийг хүртэл байна.

Дөрөв. Талуудын эрх, үүрэг

- 4.1 Б тал нь хог хаягдалыг зориулалтын машинаар ачиж, тээвэрлэх
- 4.2 Б тал нь хог хаягдал тээвэрлүүлсэн төлбөрөө энэ гэрээний 2.2-т заасны дагуу хугацаанд нь бүрэн төлнө.
- 4.3 Б тал нь төлбөр төлөх үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар тооцон тээвэрлэгч талд алданги төлнө. Нийт алдангийн хэмжээ гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.
- 4.4 Б тал нь тухайн хогийн цэгт ажиллаж буй А талын ажилчин, ажилтан нарын зааврын дагуу хог хаягдалаа буулгана.

- 4.5 Б тал нь Тэсэрч дэлбэрэх аюултай хог хаягдал болон галтай хог хаягдал ачуулахгүй байх үүрэгтэй.
- 4.6 Б тал нь хогийн цэгийн пүү ажиллуулж буй А талын ажилтнаас пүүний баримтаа авах бөгөөд тооцоо нийлэх үед баримт болох
- 4.7 Б тал нь Тээврийн хэрэгсэл, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллана.
- 4.8 Талууд өөр өөрсдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилга, холбогдох журмыг чанд мөрдөн ажиллана.
- 4.9 А тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөрөө нэхэмжлэх, шаардан авах эрхтэй.
- 4.10 Б талын хог хаягдал нь Хог хаягдалын тухай хуулинд заасанчлан аюултай хог хаягдал байгаа тохиолдолд тухайн хог хаягдалыг хүлээн авахаас татгалзах эрхтэй.
- 4.11 Б тал нь А талын чиглүүлэгчийн заасан газраас өөр газарт дур мэдэн хог хаягдалаа буулгасан тохиолдолд 250 000 /хоёр зуун тавин мянган/ төгрөг хүртэл төгрөгөөр торгоно.

Тав. Талуудын хүлээх хариуцлага

- 5.1 Талууд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, энэхүү гэрээг сахин биелүүлж ажиллана.
- 5.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

Зургаа. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах журам

- 6.1 Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар бол харилцан зөвшилцсөний үндсэн дээр нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэн эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулна.
- 6.2 Гэрээний хугацааг сунгах болон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа аль нэг тал энэ гэрээний хугацаа дуусахаас нэгээс доошгүй өдрийн өмнө нөгөө талдаа бичгээр мэдэгдэх ба уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын хоёр өдрийн дотор нөгөө тал хариу мэдэгдэнэ.
- 6.3 Гэрээний сунгалт, нэмэлт өөрчлөлтүүд нь гэрээний салшгүй хэсэг байна.

Долоо. Гэрээ цуцлах журам

- 7.1 Талууд харилцан тохиролцсоноор гэрээг цуцалж болно.
- 7.2 Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө талын санаачилгаар гэрээг цуцалж болно.
- 7.3 Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.
- 7.4 Хэрэв аль нэг тал гэрээг цуцлах саналтай бол нөгөө талдаа 1 сарын өмнө албан бичгээр мэдэгдэж, гэрээ цуцалсан тухай акт үйлдэн үйлчилгээ, төлбөр тооцоог дуусгавар болгоно.

Найм. Давагдашгүй хүчин зүйл

- 8.1 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болно.
- 8.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.



Зураг 25. Ахуйн хог хаягдал хаях гэрээг жил бүрийн 1-р сард “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-тай байгуулж, гэрээний дагуу зөвшөөрөлтэй хогийн цэгт хаядаг.



“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ


Огноо: 2023 оны 03 сарын 23
Гэрээний дугаар: Ш-23/06Н

Хүлээн авагч:
“Цэцүүх Трейд” ХХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Баянгол дүүрэг, 5-р хороо /16010/
Энэтгайнаны өргөн чөлөө 64/2 тоот
“Цэцүүх” оффис, үйлчилгээний төв
Утас: +976 70179777, +976 70180632
Цахим хаяг: www.tsettsuuh.mn

Үүсгэгч:
“Булигаар” ХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-уул
дүүрэг 2-р хороо Арьс шөрний хашаа Булигаар ХК
оффисий байр
Утас: +976 99626299,
Улсын бүртгэлийн гэрээний үндсэн дээр



Зураг 26. Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээг “Цэцүүх трейд” ХХК-тай байгуулж үйлдвэр дээр үүсэж байгаа аюултай шинж чанартай хог хаягдлыг шилжүүлж байна.





Зураг 27. Үйлдвэр дээр үүсэж буй ахуйн болон технологийн, аюултай шинжтэй хог хаягдлыг тус тусад нь түр хуримтлуулдаг.

2.6. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	БОМТ-нд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн хугацаа, давтамж	Зардал, төг	Биелэлт
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах байх	2023.1 сар	500,000	Жил бүр хэрэгжүүлэх БОМТ-г БОАЖЯ-аар батлуулдаг. Биелсэн (Зураг 28).
2	Байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, зардлыг тооцож, тухайн жилийн үйл ажиллагааны зардалд тусгаж өгөх	2023.5-12 сар	Тухайн жилийн БОМТ-нд тусгагдсан зардлаар	Байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, зардлыг тооцож, тухайн жилийн үйл ажиллагааны зардалд тусгадаг. Биелсэн.
3	Байгаль орчны аудит хийлгэх	-	-	2024 оны 1-р улиралд мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр төлөвлөсөн.
4	Газар, ус, цахилгаан ашигласны болон бусад /хог хаягдал, бохир ус зайлуулсны/, ус бохирдуулсны төлбөрийг төлөх	2023.5-12 сар	Дотоод зардлаар	Газар, ус, цахилгаан ашигласны болон бусад /хог хаягдал, бохир ус зайлуулсны/, ус бохирдуулсны төлбөрүүдийг гэрээнд заасан чиглэл хуваарийн дагуу төлж байна. Биелсэн (Төлбөрийн баримтыг тайланд хавсаргав.)
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах	2023.5-12 сар	0,0	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах Биелсэн (Зураг 25-27)
6	Үйлдвэрээс гарах бохир усны найрлагад хяналт тавих, MNS 6561:2015 стандартын ЗДХ нээс хэтрүүлэхгүй байх зааварчилгааг тогтмол өгөх, бохир усны шинжилгээг сар бүр авч, улирал тутамд тайлагнах	2023.5-12 сар	0,0	Үйлдвэрээс гарах бохир усыг төвийн бохир ус татан зайлуулах системд нийлүүлэхээс өмнө урьдчилсан цэвэрлэгээг хийдэг бөгөөд үйлдвэрийн бохир усанд жилд 2 удаа шинжилгээ хийлгэж хяналт тавьж ажилладаг. Мөн үйлдвэрт ашиглаж байгаа химийн бодис нормыг барьж ажилладаг. Биелсэн (Зураг 11).

БАТЛАВ:
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА



ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
"МОН-ИТ БУЛИГААР" ХК
ЗАХИРАЛ

"МОН-ИТ БУЛИГААР" ХК НИЙ УЛААНБААТАР ХОТ ХАН-УУЛ ДҮҮРЭГ 2-Р
ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИНЭ."АРЬС ШИР БОЛОВСРУУЛАХ
ҮЙЛДВЭР" ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2039184



ХЯНАСАН:
ХБОБЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

ПҮРЭВ, ШИНЭЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:
"МОН-ИТ БУЛИГААР" ХК
БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЭРГЭЖИЛТЭН

Б.БАЯРЦЭЦЭГ

2023 ОН

Зураг 28. 2023 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нүүр

2.7. 2023 онд хэрэгжүүлсэн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

№	БОМТ-нд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Байршил	Хэрэгжүүлсэн хугацаа, давтамж	Биелэлт
1 Агаар орчны хяналт шинжилгээ				
1.1	Агаарын тоос тоосонцор (PM _{2.5} , PM ₁₀)	Эдэлбэр газрын дотор – 1 цэг Үйлдвэрийн байранд – 1 цэг Нийт 2 цэг	2023.05 сар	Мөнх чандмань хүрд ХХК-иар Химийн бодисын няравын байранд аммиак, хүхэрт устөрөгч, азотын давхар исэл, хүхрийн давхар ислийн хэмжилтийг хийлгэхэд MNS 4990:2015, MNS 5028:2001 стандартуудтай харьцуулахад “хэвийн” гэж тодорхойлогдсон. Биелсэн (Зураг 29)
1.2	Дуу чимээ	Эдэлбэр газрын дотор – 1 цэг Үйлдвэрийн байранд – 1 цэг Нийт 2 цэг		
2 Усан орчны чанарын хяналт шинжилгээ				
2.1	Цэвэр ус: Ерөнхий хатуулаг, Урвалын орчин /рН/, исэлдэх чанар, тунгалагшил, өнгө, үнэр, амт, тунадас, анион /CL, SO ₄ , NO ₂ , NO ₃ , CO ₃ , HCO ₃ /Катион / Na ⁺ , K ⁺ , Ca ⁺⁺ , Mg ⁺⁺ , NH ₄ ⁺ . Fe ⁺⁺ , Fe ⁺⁺⁺	Төвлөрсөн шугамаар ирж буй ус	2023 5 сар	Шинжилгээ хийлгээгүй. Үйлдвэрээс гарах бохир усыг төвийн бохир ус татан зайлуулах системд нийлүүлэхээс өмнө урьдчилсан цэвэрлэгээг хийдэг бөгөөд үйлдвэрийн бохир усанд жилд 2 удаа шинжилгээ хийлгэж хяналт тавьж ажилладаг. Мөн үйлдвэрт ашиглаж байгаа химийн бодис нормыг барьж ажилладаг. Биелсэн (Зураг 30).
2.2	Үйлдвэрийн хаягдал бохир ус: Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч /БХХ5/, Химийн хэрэгцээт хүчилтөрөгч /ХХХ/, жинлэгдэх бодис, өөх тос, нийт азот	Үйлдвэрийн хаягдал бохир ус		
3 Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээ				
3.1	Ялзмагийн агууламж, ялзмагт давхаргын зузаан, механик бүтэц, нийт азот, нийт фосфор, нийт металлууд, 1см ³ дахь бактери, эмгэг төрүүлэгч бичил биетэн байгаа эсэх.	Үйлдвэр, агуулахын гадна талбай, хэрэв бохирдол үүссэн бол түүний орчимд	2023.05 сар	Үйлдвэрийн цементлээгүй талбайгаас өнгөн хөрсний дээж авч хөрсөнд агуулагдах хүнд металын үзүүдэдтүүдийг “Ханлаб” итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв. MNS 5850:2019 стандарттай харьцуулахад нийт 28 үзүүлэлтээс Cr (Хром) ЗДХ-нээс 575.7 мг/кг-ээр их гарсан бөгөөд бусад хүнд металлын агууламж ЗДХ-нээс хэтрээгүй байна. Биелсэн (Зураг 31).



Хаэсрэлт-1

Хүснэгт 1. Химийн бодисын өртөлтийн түвшин

№	Ажлын байрны нэр	Химийн бодисын нэр	MNS 4990:2015 в ЦЖД өртөлтийн ЗДХ, мг/м³	Хэмжилтийн ур дун, мг/м³	Стандартын нибцэл
1	Химийн бодисын нэрвэ	Аммиак	17	0.0	ЗХ-нд
		Хүхэрт устөрөгч	10	2.788	ЗХ-нд
		Азотын давхар исэл	2	0.378	ЗХ-нд
		Хүхрийн давхар исэл	2	<LOD	ЗХ-нд


Тайлбар: ЦЖД-Цагт жингэсэн дундаж
 ЗДХ-Зөвшөөрөхөөс доош хэмжээ
 ЗХ-Зөвшөөрөхөөс хэмжээнд
 <LOD- Илрүүлэх хязгаараас бага

Хэвсралт 2.

Хүснэгт 2. Хөдөлмөрийн нөхцөлийн ангилал


№	Ажлын байр	Хийгдсэн хэмжилтүүд				Хөдөлмөрийн нөхцөлийн анги
		Химийн үзүүлэлт				
		Амьсгал	Хүхэрт устөрөгч	Азотын давхар исэл	Хүхрийн давхар исэл	Ерөнхий анги
1	Химийн бодисын нэрвэ	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн

Зураг 29. Агаарын чанарын хэмжилтийн үр дүн



УС СУВГИЙН ҮДИРДАХ ГАЗАР
УСНЫ ТӨВ ЛАБОРАТОРИ
WATER SUPPLY & SEWERAGE AUTHORITY
CENTRAL WATER LABORATORY

Улаанбаатар 13340, Батмунх дүүрэг 4-р хороо, Б.Доржийн зузаан
 Утас: +976 70157034, өмнөтүгэд гарал



СОРИЛТЫН ТАЙЛАН
TEST REPORT

Сорилтын тайлангийн дугаар /Report No/ 23/1126
 Хүсэлт гаргагчийн нэр /Client/ Мөн Ит Бүтэц ХК
 Сорьц авсан хүний нэр, албан тушаал /Sampled by/ Т.Нэнэхаан, сорьц авлагч
 Холбоо барих мэдээлэл /Contact information/ Болорбаатар 09728638
 Дэд лабораторийн нэр /Sub laboratory name/ Хөвч


Ерөнхий шаардлага /General requirements/	MNS 6561:2018	Сорьц авсан огноо /Sampled date/	2023/05/18
Сорьцны тодорхойлолт /Sample description/	Аснүүлэх татгуурын сүлжээнд нойруулах хандлаг үз /Industrial effluent to main sewerage system/	Хураан авсан огноо /Received date/	2023/05/18
Сорьц авсан аргачлал /Sampling method/	MNS ISO 5667-6:2001	Шинжилсэн огноо /Analysed date/	2023/05/18-2023/05/20

Дэд	Сорьцны код /Sample ID/	Сорьц авсан газар /Sample location/source/	Сорьц авсан цэг /Sample point/	Хэмжээ /Sample quantity/
1	B230764	ХХД, Арьс шир боловсруулах үйлдвэр	гаргалзас	0.5л

Дэд	Шинжилгээний аргачлал /Standard method/	Шинжилсэн үзүүлэлт /Parameters/	Хэмжих нэгж /Unit/	ЗДА /SL/	B230764
Химийн шинжилгээний үр дүн /Chemical results/					
1	MNS ISO 10523:2001	Усны орчин pH / pH value/		6.9	9
2	MNS ISO 11923:2001	Умбуур бодис / Suspended solids/	mg/L	480	173.3
3	MNS ISO 6060:2001	Химийн хэрэгцээт хүчлэгтөрөгч / Chemical oxygen demand /COD-Cr/	mg/L	880	1880
4	MNS 5597:2006	Сүльфид / Sulfide/	mg/L	5	23.8
5	CS 11-0037:2008	Нийт хром / Total chromium/	mg/L	1	0


ЗДА: Батмунх дүүрэг, агууламч 11, Улаанбаатар хот

Хянасан /Verified by/



Цэцэг-Аюулын Болорбаатар
Хөвч-нөөгөөр менежер
Chemical quality manager

End of Report



Сорилтын тайланг бэлтгэжээнийхэн гэрээ үгүй, тасалгүй бол хуулгагүй. /This report would be invalid without signature of the person and stamp/

Сорилтын тайланг хэвлэжээнийхэн гэрээнийхэн гэрээнийхэн. /This test report would be invalid if altered or reproduced except as full/

Хувийн гэрээ /Printed date/ 2023/05/20 Трэйс /Page/ 1/1

2023.05 сар

Зураг 30. Үйлдвэрийн бохир усны шинжилгээний бичиг

